

## УГСААТНЫ НИЙТЛЭГИЙН ОНЦЛОГИЙН ТАЛААРХИ ЭРГЭЦҮҮЛЭЛ

И. САРУУЛ<sup>1</sup>, Ж. ДОЛГОРМАА<sup>2</sup>

<sup>1</sup> МУИС. НШУС, Угсаатны зүйн тэнхим

<sup>2</sup> МУИС. НШУС, Англи хэлний тэнхим

**Түлхүүр үг:** Угсаатны нийтлэг, нийгмийн бүлэг, онцлог шинж

**Товчлол:** Нийгмийн бүлгүүдийн нэг нь угсаатны нийтлэг байдаг бөгөөд бусад бүлгүүдээсээ ялгарах нилээд өвөрмөц онцлогтой, тэдгээрийн заримаас жагсаавал: - Харьцуулагдах онцлог (comparison), - тогтвортой оршин тогтнох онцлог (*туухэн урт удаан хугацаа, орон зайд амьдрах чадвар - features of stable existance*) - нийгмийн бусад нийтлэгүүдээс ялгагдах тодорхой шинж тэмдэгүүдтэй байдаг онцлог (definite characteristics distinguishing from other social group) - тусгаар оршин тогтнох онцлог (isolated), - угсаатан хоорондын илэрхий ялгааны онцлог (латентность) зэрэг байна. Тэхлээр нийгмийн бүлгүүдээс ялгарах угсаатны нийтлэгийн онцлогууд нь түүхэн ёсоор бүрэлдэн уламжлагдан сахигдаж байдаг нь түүний өвөрмөц шинж буюу онцлогоор тодорхойлж буй.

Өнөөгийн хүн төрөлхтний бүх нийгэм бүрэлдэх, оршин тогтоохын үндэс тулгуур нь угсаатны нийтлэг байдаг билээ. Тэд харьцангуй цөөн тооны хүн амтай угсаатны бүлгүүд юм. Эрдэмтэд судалгаагаараа угсаатны бүлгийн хүн амын тоог ойролцоогоор 3 – 5 мянга орчимд эргэлддэгийг тогтоожээ (4.т.52.). Угсаатан нь нийгмийн нэгэн нийтлэг болохын хувьд бусад нийтлэгүүдээсээ ялгарах нилээд онцлогтой. Тэдгээрийн заримаас жагсаавал:

- Харьцуулагдах онцлог (comparison). Угсаатны зэрэгцүүлсэн харьцуулалтын үндсэн дээр бодгалиуд мэдрэмжээрээ /ухамсараараа/ өөрсдийгөө бусад угсаатны нийтлэгээс “тэд ба бид”, “манайх ба харийн” гэсэн сөрөгцүүлсэн /дихотоми/ харьцуулалтаар ялган салгаж “эх орон”, “төрөлх хэл, соёл” зэрэг ойлголтуудаараа илэрхийлэн төрөлх ард түмэнтэйгээ ижилсэн нэгддэж байдаг.

- Тогтвортой оршин тогтнох онцлог (*туухэн урт удаан хугацаа, орон зайд амьдрах чадвар - features of stable existance*). Нийгэм нь улс төр, эдийн засаг, соёлын хөгжлөөсөө шалтгаалан хурдан хувьсч өөрчлөгдөж байдаг бол угсаатны хөгжил /этногенез/ түүхэн урт удаан хугацаанд залгамж холбооны байдлаар өрнөдөг. Хамгийн түгжигдмэл тогтвортой нийгэм ч гэсэн эрт орой хэзээ нэгэн цагт задардаг. Харь гаралтай хүмүүс ирж суурьших /migration/, эх орноосоо дүрвэж харьд амьдрах /emigration/ зэрэг хувьслын дүнд нэгдмэл нийгэм задрах, эсвэл урьд өмнө бие дааж байсан нийгмүүд хоорондоо нэгдэх хувилбараар харьяат гишүүнчлэлийн бүрэлдэхүүнд эрс

өөрчлөлт орно. Эдгээр өөрчлөлт нь ураг төрлийн холбоотой /квазигрупп/ угсаатны шинэ нийтлэг бүрдүүлдэгээрээ тогтвортой тогтолцоон орчилыг тогтоодог. Он цаг улирахын эрхээр угсаатны бүрэлдэхүүн хийгээд гишүүд нь үеэс үед солигдож байхад залгамж холбоо, үнэлэмжийн тогтолцоо нь ямагт улиран сахигдаж байдаг. Ийм тогтолцоо зөвхөн тогтвортой хөгжлийн нийгэмд л буй. Энэ бол угсаатны нийтлэгийн маргашгүй давуу мөн чанар болно.

- *Нийгмийн бусад нийтлэгүүдээс ялгагдах тодорхой шинж тэмдэгүүдтэй байдаг онцлог /definite characteristics distinguishing from other social group/. Тэдгээр шинжүүдэд:* - Нутаг дэвсгэрийн газар зүйн байршил, байгаль – цаг уурын нəхцəл /homeland of ancestors/, арьстны, хэлний, шашны, соёлын, эд өлгийн, бие махбодын зэрэг ялгааны онцлог шинжүүдээр хязгаарлагдахгүй. Тэхдээ нийгмийн бүх шинж угсаатанд агуулагддаггүй. Тухайлбал, нутаг дэвсгэрийн эсвэл улс төрийн бүрэн эрхт /sovereignty/ байдалтай байх албагүй. Тиймд угсаатны нийтлэг нь ямар ч нийгмийн хэсэг байх, эсвэл хэдэн ч нийгмийн бүрэлдэхүүнд харьяалагдаж болно.

- *Тусгаар оршин тогтнох онцлог /isolated/. Байгалийн байц /уул, ус гэх мэт/, хэл, арьс, шашин, соёлын зэрэг ялгааны саад бэрхшээлүүдийн /barrier/ улмаас угсаатнууд бие биенээсээ салангад тусгаардуу, өвөр хоорондын харилцаа холбоо сул түгжигдмэл байдалтай оршиход хүргэдэг нь угсаатны нийтлэгийн бас нэгэн өвөрмөц онцлогийн тодорхойлолт юм.*

- *Угсаатан хоорондын илэрхий ялгааны онцлог (Латентность).* Эдийн засаг, нийгэм, улс төр, соёлын хөгжлийн явцад угсаатны онцлог далд (нойрсох мэт) нуугдана. Харин улс төр, нийгэм – эдийн засаг ба бусад харилцаанууд нь зөрчилдөхийн хирээр угсаатны тэмцэл мөргөлдөөнүүд хурцдаж нийгмийг хамардаг. Эл нəхцəлд угсаатны ухамсар сэргэж, дотоод үйл ажиллагаа нь идэвхжин нийт угсаатны нийгмийн эв нэгдлийн хөдөлгөөн өрнөж, харийнхнаас давуутай онцлог сэтгэлгээг төрүүлж, тэдэнтэй сөрөгцөх байдалд хүргэдэг зэрэг онцлогуудаар тогтохгүй байна.

Тэхлээр нийгмийн бүлгүүдээс ялгарах угсаатны нийтлэгийн онцлогууд нь юуны өмнө түүхэн ёсоор бүрэлдэж, улмаар үеэс үед уламжлагдаж, үнэлэмжийн тогтолцоо нь хэвээр сахигдаж байдаг нь түүний өвөрмөц шинж буюу онцлог юм.

**Ашигласан ном зохиол**

1. "Этнос и политика". Хрестоматия. Автор – составитель д-р ист. наук А.А. Празаускас. – М., 2000.
2. Riggs, Fred F6 Ethnicity. 1985. P.11-23.
3. Despres, Louis. Ethnocity and Resource Competition in Plural Societies. The Hague, Paris: Mounton, 1975. P.195-199.
4. Бабосов Е.М. Прикладная социология. – Минск, 2000.

**Ethnic common characteristics distinguishing  
from the social groups.**

Ethnic common characteristics are the base of forming and existing of the present mankind society. Therefore it has some features distinguishing from other common characteristics. They are: 1. Specific to be compared. 2. Stable existence or features of living in the world during long historic period. 3. It has particular signs distinguishing from other common characteristics. 4. Peculiarity of isolated existence. 5. Specific features of distinction between ethnics. Therefore specific features of distinction from other groups are formed historically and inherited in common characteristics. There are specific features of common characteristics.